

Израилын хуарангийн туршлагууд

Туршлага #1

Арван хоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Жорж Алберт Смит Израилын хуаранд аяллынх нь үеэр тулгарсан зарим нөхцөл байдлыг дурсав.



Бошиглогч Иосеф Смит бүхий л аяллын турш ихээхэн ядарч туйлдсан байсан. Хуарангийнхныг халамжлан, тэргүүлэхээс гадна тэрээр ихэнх цагаараа явган алхдаг байсан ба жилийн хамгийн халуун улиралд өдөрт 40–65 км алхсанаас болж хөл нь цэврүүтэж, цус гаран, өвддөг байв. Гэхдээ тэр аяллын туршид ганц ч удаа гомдоллож, бувтнаагүй. Хуарангийн эрчүүдийн ихэнх нь хөл өвдөж, цэврүүтэж, эцэж туйлдтал удаан явж, хоол хүнсний хангамж хомс байгаа талаар мөн талхны чанар, эрдэнэ шишийн гурилаар хийсэн гамбир, өмхийрсөн цөцгийн тос, гашуун зөгийн бал, өтсөн гахайн утсан мах, бяслаг гэх мэт зүйлийн талаар түүнд хандан гомдоллож байв. Бид Сионы хуарангийнхан байсан ч олонх маань залбирдаггүй, бодлогогүй, халамжгүй, болгоомжгүй, мунхаг, хорон санаатай байсныг мэдээгүй юм. Иосеф биднийг хүүхэд адил хүлцэж, зааж сургаж байсан. Гэсэн хэдий ч хуаранд хэзээ ч бувтнадаггүй, удирдагчийн маань хүссэнээр хийх хүсэлтэй, үргэлж бэлэн байдаг хүмүүс ч олон байв. (George A. Smith, in *Teachings of Presidents of the Church: Joseph Smith* [2007], 287–88)

- Хуарангийн гишүүд яг ижил нөхцөл байдалд яагаад өөр өөр байдлаар хариу үйлдэл үзүүлсэн гэж та бодож байна вэ?
- Аврагчийг дагахаар хичээх үед хэцүү зүйл тохиолдох үед юу бидэнд эерэг хандлагатай байхад туслах вэ?

Туршлага #2

Сургаал ба Гэрээ 103:20-ийг болон Тэргүүн зөвлөлийн ерөнхийлөгч Хибэр Ч.Кимбаллын (1801–1868) дараах мэдэгдлийг уншина уу.

Дайснууд хүчирхийлэл үйлдэхээр байнга заналхийлж байсан ч бид үүнээс айсангүй, бас хээрийн аянаа үргэлжлүүлэхээс ч



ухарсангүй, учир нь Бурхан бидэнтэй хамт байлаа, мөн Түүний тэнгэр элч нар бидний өмнө явж, манай жижигхэн бүлгийнхэн итгэлдээ гуйвшгүй, тууштай байлаа. Тэнгэр элч нар бидний хамтрагчид гэдгийг бид мэдэж байв, яагаад гэвэл бид тэднийг харж байсан юм. (Heber C. Kimball, in *Teachings of Presidents of the Church: Joseph Smith* [2007], 288–89)

- Хэрэв та Израилын хуарангийн нэгэн хэсэг байсан бол энэ адислал танд хэрхэн нөлөөлөх байсан гэж та бодож байна вэ?
- Өнөө үед Их Эзэн Өөрийн дагалдагчдыг хэцүү зүйл хийхэд нь ямар арга замаар тусалдаг вэ?

Туршлага #3

Израилын хуаранг Жаксон гүнлэгээс ердөө ганцхан хоногийн зайтай байхад зэвсэглэсэн таван эр тэдэн рүү ойртон ирэв. Хуаран руу дайрахаар гурван зуу гаруй хүн замдаа явж байгаа гэж тэд сайрхжээ. Хуарангийн гишүүдийг юу хийхээ ярилцаж байхад бошиглогч Иосеф Смит: “Бат зогсож, Бурханы авралыг хар” гэж айлдсан.

20 минутын дараа аадар бороо хуаранг дайрч өнгөрөв. Борооны улмаас ойролцоох голын ус нэлээдгүй нэмэгдэж, дайснууд нь гол гаталж довтлох боломжгүй болсон байна. Израилын хуарангийн олон гишүүн ойролцоох жижиг сүмд хоргодох газар олов. Хэсэг хормын дараа бороонд нэвт норсон Иосеф Смит сүмд орж ирээд, “Бурхан энэ шуургыг удирдаж байна!” гэв.

Шуурга болсны маргааш өглөө нь хуарангийн гишүүд майхан, хэрэгсэл нь норж, тарсан байхыг харсан боловч хэн ч тэдэн рүү дайраагүй байлаа (*Saints: The Story of the Church of Jesus Christ in the Latter Days, vol. 1, The Standard of Truth, 1815–1846* [2018], 203–04-өөс иш татаж, хураангуйлав).

- Хэрэв та Израилын хуарангийн нэг хэсэг байсан бол энэ туршлага бошиглогч Иосеф Смитийн талаарх таны бодолд хэрхэн нөлөөлж болох байсан бэ?
- Энэ туршлага амьдралын тань хэцүү цаг үед Бурханы талаар танд юу зааж байна вэ?